

**БАЯНХОНГОР АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2023 ОНЫ
АЖЛЫН ТАЙЛАН**

2023 оны 12 дугаар сарын 28

Номгон

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны “Дотоод аудитын дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоол, Сангийн сайдын 2016 оны “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт батлах тухай” 107 дугаар тушаал, 2019 оны “Аргачлал батлах тухай” 268 дугаар тушаал болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх, дүгнэлт, акт, албан шаардлага, зөвлөмж бичих, эрсдэлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан.

Төрийн хяналтын чанар, үр нөлөөг дээшлүүлж, хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулахад чиглүүлж, шалгуулагч этгээдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудыг сурталчилах, өргөдөл гомдол, санал хүсэлтийг цаг алдалгүй шийдвэрлэж хариуг хуулийн хугацаанд өгөх, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага тооцохоор холбогдох байгууллагад уламжилж, хяналт шалгалтын ажлын тогтолцоо шинэчлэлтэй холбоотой аж ахуйн нэгж, байгууллагуудын дотоодын хяналтыг бий болгох, зөрчлийн мөрөөр биш зөрчил гарахаас өмнө урьдчилан сэргийлэхэд ажлаа чиглүүлэн хэрэглэгчийн эрхэд хамаарал бүхий хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг сурталчилах, дотоод аудит, хяналт шалгалтыг ил тод, нээлттэй болгох ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны бүтэц орон тоо:

№	Албан тушаалын нэр	Тоо	Тайлбар
1	2	3	4
1	Албаны дарга, Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч	1	
2	Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор	2	
3	Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч	1	Орон тоо дутуу
3	Ахлах дотоод аудитор	1	Орон тоо дутуу
4	Дотоод аудитор	3	
5	Хүний нөөц, нягтлан бодогч, дотоод ажилтан, архив, бичиг хэрэг	1	1 албан хаагч хавсарч ажилладаг.
6	Гэрээт ажилтан	2	
	Нийт дүн	11	

Санхүүгийн байдал :

№	Төсөв	Зарцуулалт	Тайлбар
1	2	3	4
1	Цалин хөлс	178,906,689.79	
2	Дотоод албан томилолт	30,680,000.00	
3	Бичиг хэргийн зардал	3,600,000.00	
4	Тээвэр шатахуун	15,000,000.00	
	Нийт	228,186,689.79	

Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт:

№	Нэр төрөл	Дотоод аудитын тоо	Санхүүгийн хяналт шалгалтын тоо	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт тоо
1	2	3	4	5
1	Нийт арга хэмжээний төрөл	21	54	5
2	Биелэлтийн (хувь)	100	100	100

Хяналт шалгалтын мэдээлэл:

№	Акт		Албан шаардлага		Нийт хяналт шалгалтын тоо	Нийт зөрчлийн дүн (мянган/төг)
	Тоо	Дүн (мянган/төг)	Тоо	Дүн (мянган/төг)		
1	2	3	4	5	6	7
1	78	147,918.0	25	283,796.3	59	431,714.2
2	Нийт дүн	147,918.0	Нийт дүн	283,796.3	Нийт дүн	431,714.2

Нийтлэг зөрчлүүд:

Санхүүгийн хяналт шалгалт, аудитын үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.3-т “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна” гэсэн заалтын хүрээнд албаны даргын 2023 онд баталсан хяналт шалгалт, дотоод аудит хийх хуваарийн дагуу 2023 оны байдлаар 28 удирдамж боловсруулан төлөвлөгөөт 54, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 5, дотоод аудит 21 нийт 80 санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг хийж 48 заалт бүхий 12 зөвлөмж хүргүүлэн, улсын ахлах байцаагчийн 78 актын 147,918.0 мянган төгрөгийн хохирол тооцож, аймгийн төсөвт 59,349.7 мянган төгрөгийг, тухайн байгууллагын дансанд 71,690.2 мянган төгрөгийг оруулахаар шийдвэрлэснээс аймгийн төсвийн орлогод 45,991.166 мянган төгрөгийг төвлөрүүлж, хугацаа болоогүй төлбөрийн актын үлдэгдэл 25,699.034 мянган төгрөг, актын барагдуулалт 72.6 хувьтай. Илэрсэн зөрчлийг ангилан авч үзвэл 14.3 хувь нь томилолтын зардал, 13.2 хувь нь шатахууны зардал, 13.2 хувь нь өндөр үнээр авах болон хямд үнээр худалдсанаас, 13.5 хувь нь зориулалт бусаар зарцуулснаас, 13.8 хувь нь үндсэн болон анхан шатны баримтгүй зарцуулснаас, 6.8 хувь нь амралтын мөнгө илүү

олгосон, 16.9 хувь нь цалин хөлс илүү болон дутуу олгосноос, 8.3 хувь нь ашиглаж дутагдуулснаас голлон шалтгаалсан байна.

Чанарын үнэлгээ:

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас ирүүлсэн 2022 оны зөвлөмжийн хүрээнд Дотоод аудитын аргачлалын хүрээнд төлөвлөгөө боловсруулан ажлын 14 баримтаар албан хаагч тус бүр сургалтыг дотооддоо зохион байгуулж, нэг ойлголтод хүрч, дотоод аудитын ажлыг хийж гүйцэтгэж байна.

Сангийн яамны Дотоод аудитын хорооны 2021 оны 06 дугаар тогтоолын биелэлтийг гарган Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын хүргүүлэн ажилласан.

Албаны хэмжээнд Дотоод аудиторчуудын институтээс боловсруулан Дотоод аудиторчуудын нэгжид чанарын баталгаажуулалт гарын авлагын хүрээнд албаны үйл ажиллагаанд хийх чанарын үнэлгээний журмын төслийг боловсруулан, сургалтыг албан хаагч нарт зохион байгуулан ажилласан.

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын чанарын үнэлгээнд хамрагдаж холбогдох материалуудыг цахимаар хүргүүлэн ажилласан.

Тухайн онд хийгдсэн онцлог ажил:

№	Онцлог ажлын нэр	Тайлбар
1	2	3
1	Албаны цахим системийг хэвийн ажиллагаанд оруулсан байдал	1.Эрсдэлд суурилсан дотоод аудит, хяналт шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэргэжил арга зүй, зөвлөгөө өгөх замаар төсвийн сахилга батыг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, хараат бус бие даасан, бодитой баталгаажуулах болон зөвлөх үйлчилгээг үзүүлнэ гэсэн зорилтыг дэвшүүлэн https://sankhuu.bkh.gov.mn цахим системд мэдээллүүдийг нийтлэн ажилласан. 2.Албаны 2014-2020 оны байнгын баримтыг Төрийн архивын цахим санд бүрэн шилжүүлсэн.
2	Төрийн байгууллагуудын цахим системийн ашиглалтыг сайжруулсан байдал	1.Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн ERP цахим системийг бүрэн ашиглалтаар "Архив, бичиг хэргийн ажилтнуудын нэгдсэн зөвлөгөөн" дээр Архив, бичиг хэргийн ажилтан танилцуулгыг хийсэн. 2.Албаны баримт бичгийн цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг https://erp.e-mongolia.mn/ системээр зохион байгуулан өдөр тутмынхаа үйл ажиллагаанд хэрэглэж хэвшсэн. 3.Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын системээр ирсэн албан бичиг -238 хүлээн авч цаг хугацаанд шийдвэрлэж, албанаас явсан албан бичиг-188 бүртгэж цахим системээр бусад байгууллагад хүргүүлэн ажилласан. 4.Албан бичиг солилцооны дундын DOCX системийн үйл ажиллагааны тухай болон түүнд хэрхэн холбогдож албан бичиг солилцох талаар цахим сургалтад хамрагдан нэвтрэх эрх нээлгэн үйл ажиллагаандаа туршилтаар ашиглаж байна.

1	2	3
		<p>5.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын удирдлага, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтнүүдэд "Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт гаргах арга зүйн" сургалтыг нийт 82 албан хаагч нарт хийж, сайн туршлагыг солилцсон.</p> <p>6.Шилэн дансны цахим системийн сургалтыг 200 байгууллагын нягтлан бодогч, төсөв хариуцсан албан хаагч нарт зохион байгуулсан.</p> <p>7.Шилэн дансны цахим систем өөрчлөгдсөнтэй холбогдуулан Санхүү төрийн сангийн хэлтсээс зохион байгуулсан "Төрийн сангийн цахим шинэчлэл" ажлын хүрээнд шилэн дансны котентийг бэлтгэн олон нийтэд хүргэсэн.</p> <p>8.Төрийн албаны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, дүрэм журмын шинэчлэлийн сургалтыг Хүүхдийн Тэмүжин театрын хамт олонтой хамтран зохион байгуулж, Дотоод аудитыг хийж ажлын байранд зөвлөн тусалж ажилласан.</p>

Сургалтад хамрагдсан тухай мэдээлэл:

№	Сургалтын чиглэл	Хамрагдсан байдал
1	2	3
1	1.Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	<p>1.Удирдлагын академи, аймгийн Засаг даргын Тамгын газраас хамтран зохион байгуулсан Алсын хараа 2050 хөтөлбөрийн сургалтад албан хаагчид бүрэн хамрагдаж, шалгалтыг өгч 100 хувь гэрчилгээг авсан.</p> <p>2.Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулсан багц сургалтад албан хаагчид бүрэн хамрагдсан.</p> <p>3.Тогтвортой амьжиргаа төслөөс зохион байгуулсан Орон нутгийн хөгжлийн журмын хэрэгжилтэд хийх хяналт сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулсан.</p> <p>4.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хэл шинжлэлийн хүрээлэнгээс зохион байгуулсан "Хос бичиг"-ийн сургалтад 2 албан хаагч хамруулж, хос бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлсэн.</p> <p>5.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг пүрэв гарагийн цахим сургалтад хүний ажилтан 12 удаа хамрагдсан.</p> <p>6.Албаны бичгийн хэргийн ажилтны зохион байгуулсан https://erp.e-mongolia.mn/ системийн ашиглалтыг сайжруулах сургалтад 6 албан хаагч хамрагдаж цахим систем ашиглах мэдлэгээ дээшлүүлсэн.</p> <p>7.Төрийн архив албан хэрэг хөтлөлт шинэчлэл өөрчлөлт зөвлөгөөнд оролцож 2022 оны 01 дүгээр сарын 09-11-ний өдрүүдийн зөвлөгөөнд оролцож Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар мэдлэгээ дээшлүүлэв. Тус арга хэмжээний үеэр https://erp.e-mongolia.mn/ системийн ашиглалтын талаарх мэдээллийг нийт зөвлөгөөнд оролцогч архив, бичиг хэргийн ажилтнуудад өгч ажилласан.</p> <p>8.Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсоох олон улсын өдрийг тохиолдуулан "Гэрэлт ирээдүйд гар бүү хүр" урьдчилан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газраас зохион байгуулсан сургалтад албан хаагчид бүрэн хамрагдсан.</p>

1	2	3
		<p>9.Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас зохион байгуулсан Хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлын дадлага ажил сургалтад 1 албан хаагч хамруулсан.</p> <p>10.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуусан Ёс зүйтэй төрийн алба сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулсан.</p> <p>11.Хууль эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан Эрх зүйн хөтчийн сургалтад 1 албан хаагч хамруулсан.</p> <p>12.Цахим хөгжлийн яамнаас зохион байгуулсан Төрийн албан хаагчдыг чадваржуулах сургалтад 2 албан хаагч хамруулсан.</p>
2	<p>2.Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт</p>	<p>1.Удирдлагын академийн дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад 1 албан хаагч хамруулсан.</p> <p>2.Хөдөө аж ахуй их сургуулийн магистрын сургалтад 1 албан хаагчийг суралцах нөхцөл боломжоор хангасан.</p> <p>3.Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохион байгуулсан мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авах сургалтад 2 албан хаагчийг хамруулсан.</p> <p>4.Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас зохион байгуулсан "Дотоод аудитуудын цахим системийн ур чадвар"-ыг дээшлүүлэх сургалтад 4 албан хаагч хамруулав.</p> <p>5.Сангийн яамны ирүүлсэн чиглэлийн дагуу Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Баянхонгор аймгийн бүсийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албадын туршлага солилцож сургалт, уулзалтыг хамтран зохион байгуулсан.</p> <p>6.Ховд аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албадын албан хаагч нарт Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны албан хаагч нар Дотоод аудит хийх үзүүлэх сургалтыг хийсэн.</p> <p>7.Бизкон аудитор ХХК-аас зохион байгуулсан Монгол Улсын Мэргэшсэн дотоод аудиторын сургалтад 1 албан хаагч хамруулсан.</p> <p>8.Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохион байгуулсан Мэргэшсэн аудиторын сургалтад албаны дарга хамрагдаж, Мэргэшсэн аудитор болсон.</p> <p>9.Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас зохион байгуулсан "Дотоод аудитуудын цахим системийн ур чадвар"-ыг дээшлүүлэх сургалтад 4 албан хаагч хамруулав.</p>
3	<p>3.Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн</p>	<p>Төрийн хэмнэлтийн тухай хуулиар зардлыг хэмнэсэн тусгай зардал төсөвт тусгаж өгөөгүй боловч албан хаагчид хувийн зардлаар суралцаж байна.</p> <p>Тус албанаас төрийн албаны шилжилт хөдөлгөөнийг хийсэн албан хаагч байхгүй болно.</p>
	Нийт	Албан хаагчдыг 3 чиглэлээр 21 сургалтад хамруулсан.

Дүгнэлт:

Аймгийн Засаг даргаар 2023 онд батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар 95.1 хувьтай хангаж ажилласан.

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын тайлан мэдээг хугацаанд холбогдох заавар журмын дагуу тайлагнан ажиллаж, хяналт шинжилгээ үнэлгээрэй аймгийн

хэмжээнд төрийн байгууллагуудын дунд хангалттай сайн үнэлэгдэж гутгаар байр эзэлж, 1,8 сая төгрөгөөр шагнуулсан.

Аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын хорооны хурлаар баталсан төлөвлөгөөний дагуу ажиллаж жилийн эцсийн байдлаар дотоод аудитын ажил 21 төлөвлөгдсөнөөс 21 гүйцэтгэж 100 хувьтай, санхүүгийн хяналт шалгалтын ажил 54 төлөвлөгдсөнөөс 54 төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, нэмэлтээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт 5 хийж хяналт шалгалтын ажил 100 хувьтай биелсэн байна.

Санал:

Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг биелүүлээгүй нөхцөлд нэгдсэн арга хэмжээ авах хуулийн санкцтай болох зохицуулалтыг хийх.

Хууль эрх зүйн болон дотоодод мөрдөгдөж буй дүрэм журмыг гарын авлагыг гар утасны аппликейшнтэй болох

Дотоод аудиттай холбоотой судалгааны маягт болон гүйцэтгэлийн шатанд ашиглаж байгаа холбогдох маягт, хяналтын хуудсыг улсын хэмжээнд нэгдсэн арга зүйгээр ханган, ашиглаж үр дүнг тооцдог болох.

Орон нутгийн төсвөөс санхүүжилтийг авч үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч хөдөө ажиллахад шаардлагатай авто машины асуудлыг шийдвэрлүүлэх.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад төсөв хүрэлцдэггүй тул боловсон хүчний хомсдол бий болж, хүний нөөцийн дутагдалтай ажиллаж байгаа цаашид хүний нөөцийн асуудлыг шийдвэрлүүлэх.

Шилэн дансны цахим системийн шинэчлэл хийгдсэнтэй холбогдуулан Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны хяналт эрхийн тохиргоог бүрэн хийж хэвийн ажиллагаанд оруулах.

Улсын байцаагч, дотоод аудиторчуудын чадавхыг сайжруулахад анхаарч дотоод аудитын мэргэжлийн сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

Дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нарын техник хэрэгсэл, тоног, төхөөрөмжийг шинэчлэх асуудлыг аймгийн Засаг дарга, Сангийн сайдтай хамтран ажиллах гэрээнд тусгуулах.

Линк: https://www.facebook.com/permalink.php?story_fbid=pfbid02vSeQ7CF3HFu5cagwwL7S9n69p3nvwv4EL5L2Ri2qwK3wwmX23D1RCE3txexPuMXI&id=100090389671179

ТАЙЛАН БИЧСЭН
ДАРГА  Л.ЖАРГАЛЦЭЦЭГ

